



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

“Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028”
арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Чингэлтэй дүүргийн хэмжээнд хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж, хөгжүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, ёс зүйн сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилго бүхий “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА

Т.УЛАМБАЯР



1150109052

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 05 дүгээр сарын 21-ны
өдрийн 17 дугаар тогтоолын хавсралт

“ХҮНИЙ НӨӨЦ, НИЙГМИЙН БАТАЛГАА-2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг.Нийтлэг үндэслэл

Аливаа байгууллагад хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, зорьсон зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэргэжил, боловсрол, туршлагын хувьд шаардлага хангахуйц хүний нөөцийг бүрдүүлэх, нөөцийг үр ашигтайгаар хуваарилах зорилгоор тодорхой, дэс дараалсан үйл ажиллагааг боломжит хугацаанд хэрэгжүүлэх шаардлага тулгардаг.

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус үндэслэн мэргэшсэн, чадварлаг, иргэндээ түргэн шуурхай үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэх хүрээнд Чингэлтэй дүүргийн төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг мэдлэг боловсролтой, дадлага туршлагатай, мэргэшлийн ур чадвартай, ёс зүйтэй, өөрчлөлтөд дасан зохицох чадвар бүхий төрийн албан хаагчдын тусламжтайгаар хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Иймд иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, чанартай үйлчилгээг түргэн шуурхай хүргэх хүрээнд чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийг бэлтгэх, сургах, авьяас чадварыг нь хөгжүүлэх, ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах асуудал нь нэн чухал байна.

Хоёр.Арга хэмжээний зорилго

“Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028” арга хэмжээний зорилго нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар болон дүүргийн харьяа төр, захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, төрийн албан хаагчдыг сургаж, хөгжүүлэх, тэдний ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж, харилцаа хандлагыг сайжруулахад оршино.

Гурав.Арга хэмжээний зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1:Ажлын байрны хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1.Хүний нөөцийн эрсдэлийн судалгаа, нөөц бүрдүүлэлтийн судалгааг хийж, судалгаанд суурилсан хүний нөөцийг төлөвлөх;

1.2.Их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, оюутнуудыг дадлага хийлгэх, төгссөний дараа ажлын байраар хангах замаар хүний нөөцийг бүрдүүлэх;

1.3.Төрийн албаны тухай хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан албан хаагчдыг “чадахуйн зарчим” (мерит)-ыг үндэслэн томилох, шатлан дэвшүүлэх замаар сул орон тоог нөхөж ажиллах;

1.4.Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор албан хаагчийг хуульд заасан үндэслэл журмын дагуу өөр албан тушаалд болон байгууллага хооронд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах;

Хүрэх үр дүн:

- Хүний нөөцийн эрсдэлийн болон нөөц бүрдүүлэлтийн судалгаа хийснээр ирээдүйд хомсдол үүсэж болох нөхцөлийг урьдчилан тодорхойлох, нөөцийг үр ашигтай, оновчтой хуваарилах боломж бүрдэнэ.
- Эрсдэлийн болон нөөц бүрдүүлэлтийн судалгаанд үндэслэн шаардлагатай сул орон тоог шинэ төгсөгчөөр бүрдүүлэх, төрийн албан хаагчийг сэлгэх нөхцөл бүрдэнэ.
- Анхан шатны нэгжид ажиллаж байгаа чадварлаг төрийн албан хаагчийн шатлан дэвшүүлэх замаар нөөцийг бүрдүүлнэ.

Зорилт 2:Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдэд хүргэх үйлчилгээг түргэн шуурхай, ил тод болгоно.

2.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO стандартыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2.2.Төрийн үйлчилгээний төлөвлөлтийг хийж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний шат дамжлага, давхардлыг бууруулах;

2.3.Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд суурилж, төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар иргэдийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

Хүрэх үр дүн:

- төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, хандлага, төрийн байгууллагын менежментийн тогтолцоо, төсвийн зарцуулалт, хийдэл арилж, дүүргийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ.

- Төрийн үйлчилгээний ил тод байдал нэмэгдэж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чирэгдэл, шат дамжлага багасна.
- Хяналтын тогтолцоо тодорхой, ойлгомжтой болж, иргэдэд хүрэх үйлчилгээний чанар сайжирна.

Зорилт 3:Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлнэ.

3.1.Албан хаагчдыг гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудын туршлагыг судлах урт болон богино хугацааны сургалтад үе шаттайгаар хамруулах;

3.2.Албан хаагчдын сургалтын төлөвлөгөө боловсруулж, шинэ албан хаагчдыг ажлын байранд чиглүүлэх сургалтад, олон жил ажиллаж байгаа албан хаагчдыг давтан сургах ажлыг тогтмол зохион байгуулах;

Хүрэх үр дүн:

- Албан хаагчид гадаад, дотоодын ижил төстэй байгууллагуудад суралцаж, мэдлэг, туршлага нэмэгдэнэ.
- Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.

Зорилт 4:Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

4.1.Албан хаагчдыг албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай сүүлийн үеийн тоног төхөөрөмж, өрөө тасалгаагаар хангаж, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах;

4.2.Албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн цалин хөлс, шагнал урамшуулал, бүтээлч санал, санаачилга, оролцоо, үр дүнг үндэслэн урамшуулал олгох шалгуур үзүүлэлт, журмыг боловсруулж, ил тод мөрдүүлэх;

4.3.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр тогтмол эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийг нь дэмжих;

4.4.Чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, соёл урлаг, спорт, бие бялдаржуулах чиглэлийн ажлыг тогтмол зохион байгуулж, стресс менежментийн аргуудад сургах;

4.5.Албан хаагчдын амьдралын чанарыг сайжруулах зорилгоор хашаа байшин, орон сууцны нөхцөлөө сайжруулах, орон сууцны хөнгөлөлттэй зээл болон бусад зээлд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

Хүрэх үр дүн:

- Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа явуулах ажлын байрны нөхцөл сайжирна, сэтгэл ханамж дээшилнэ.
- Албан хаагчдын шагнал урамшуулал, нэмэлт цалин хөлс олгох нөхцөл шалгуур ил тод, шударга болно.

- Албан хаагчдын эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.
- Албан хаагчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэгдэж, тусламж дэмжлэг олгох, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах нөхцөл бүрдэнэ.

Зорилт 5: Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

5.1. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, гүйцэтгэлд суурилсан хариуцлага тооцох тогтолцоо бүрдүүлэх;

5.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг тогтмол хийх, арга зүйн удирдлагаар хангах;

5.3. Албан хаагчийн ёс зүйн зөрчил гарахад нөлөөлж буй шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийж, зөрчлийг бууруулах;

Хүрэх үр дүн:

- Албан хаагчид ёс зүй, сахилга хариуцлагатай ажиллаж, байгууллагын дотоод соёл, харилцаа, хамтын ажиллагаа хүндэтгэлтэй, мэргэжлийн түвшинд шилжиж, аливаа асуудлыг шуурхай, хариуцлагатай шийдвэрлэх боломж бүрдэнэ.
- Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын талаарх хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, урьдчилан сэргийлэх боломж бий болно.
- Зөрчлийн шалтгаан нөхцөл тодорхой болж, зөрчлийг бууруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

4.1. "Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028" арга хэмжээг 2025-2028 оны хооронд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

4.2.1. Улс, нийслэл, орон нутгийн төсөв.

4.2.2. Олон улсын байгууллага, хандивлагчдаас өгч буй тусламж, дэмжлэг, хуулиар зөвшөөрөгдсөн хандив.

4.2.3. Төр, олон нийт, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хандив, тусламж.

4.2.4. Бусад эх үүсвэр.

Тав. Хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт, хамрах хүрээ

5.1.“Хүний нөөц, нийгмийн баталгаа-2028” арга хэмжээг Монгол Улсын Засгийн газар, нийслэлийн Засаг даргын бодлого шийдвэр, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд уялдуулан зохион байгуулж, хэрэгжилтийг хангана.

5.2.Арга хэмжээнд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын төрийн албан хаагчдыг хамруулна.

5.3.Хэрэгжүүлэгч байгууллага нь уг арга хэмжээ болон бусад холбогдох хууль тогтоомжид заагдаагүй асуудлыг байгууллагын холбогдох журамд тусган хэрэгжүүлнэ.

Зургаа.Хяналт шинжилгээ, үнэлгээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

6.1.Арга хэмжээний хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

6.2.Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

Шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин			
			2025 он	2026 он	2027 он	2028 он
Зорилт 1:Ажлын байрны хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ.						
Хүний нөөцийн эрсдэлийн болон нөөцийн судалгааны тоо	тоо	0	1	2	3	4
Шинэ төгсөгчдийн сул орон тоо нөхсөн хувь	тоо	5%	10%	20%	30%	40%
Мерит зарчмаар шатлан дэвшиж ажилласан албан хаагчдын эзлэх хувь	Хувь	10%	20%	30%	40%	50%
Зорилт 2:Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдэд хүргэх үйлчилгээг түргэн шуурхай, ил тод болгоно.						
Олон улсын чанарын стандарт нэвтрүүлсэн тоо	Тоо	5	10	15	20	25
Төрийн үйлчилгээ тус бүрээр хийсэн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны тоо	Тоо	1	5	10	15	20
Зорилт 3:Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлнэ.						
Туршлага судлах урт болон богино хугацаанд хамрагдсан албан хаагчдын хувь	Хувь	Бэлэн бус	20%	30%	40%	50%
Шинэ албан хаагчдын чиглүүлэх сургалт нэвтрүүлсэн байгууллагын тоо	Тоо	0	10	15	20	25

Давтан сургалтад хамрагдаж, мэдлэг мэргэшил дээшлүүлсэн албан хаагчийн тоо	Хувь	10%	20%	30%	40%	50%
Зорилт 4:Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.						
Албан хаагчдын ажиллах орчинд шаардлагатай тоног төхөөрөмж, өрөө тасалгааны сайжруулсан хувь	Хувь	70%	75%	80%	90%	100 %
Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан хувь	Хувь	10%	30%	50%	70%	100 %
Шагнал урамшуулал олгох, сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт, ил тод, нээлттэй болсон журмын тоо	Тоо	1	10	15	20	25
Албан хаагчдын хашаа байшин, орон сууцны нөхцөл сайжирсан хувь	Хувь	20%	30%	40%	50%	60%
Орон сууцны хөнгөлөлттэй болон бусад зээлд хамрагдсан албан хаагчдын хувь	Хувь	Бэлэн бус	20%	30%	40%	50%
Зорилт 5:Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.						
Албан хаагчдын ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол, ёс зүйн зөрчлийн хувь	Хувь	10%	7%	5%	3%	0%
Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Тоо	Бэлэн бус	50%	70%	90%	100 %